

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МХБ ТӨХК-ийн ТУЗ-ийн
2014 оны 16 дугаар сарын 20-ны
өдрийн 10/11/12 тоот тогтоолын хавсралт
• ТУЗ •

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
“БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”**

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1 дүгээр зүйл. Журмын зорилт
- 2 дугаар зүйл. Хууль журам
- 3 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тайлбар
- 4 дүгээр зүйл. Бүртгэлийн болон хяналтын албаны чиг үүрэг

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

- 5 дугаар зүйл. Үнэт цаас бүртгэх үе шат
- 6 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргах
- 7 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авч хянах
- 8 дугаар зүйл. Үнэт цаас бүртгэх
- 9 дүгээр зүйл. Үнэт цаас бүртгэхээс татгалзах

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ АРГА

- 10 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх арга

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

- 11 дүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн шалгуур
- 12 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуур
- 13 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуур
- 14 дүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн III ангиллын нөхцөл, шалгуур
- 15 дугаар зүйл. Бүртгэлийн шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх

ТАВДУГААР БҮЛЭГ. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

- 16 дугаар зүйл. Өрийн хэрэгслийн шалгуур

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

- 17 дугаар зүйл. Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг
- 18 дугаар зүйл. Мэдээлэл ил тод болгох

ДОЛДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ

- 19 дүгээр зүйл. Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг бүртгэх

НАЙМДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 20 дугаар зүйл. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах
- 21 дүгээр зүйл. Бүртгэлийн ангилал өгсүүлж бүртгэх
- 22 дугаар зүйл. Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэх

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

- 23 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах

АРВАНДУГААР БҮЛЭГ. БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХӨЛС

24 дүгээр зүйл. Бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл. Хууль, журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. БУСАД

26 угаар зүйл. Маргаан шийдвэрлүүлэх

27 дугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

Хавсралт 1. Бүрдүүлэх материалын жагсаалт

Маягт 1. Бүртгэлийн өргөдлийн маягт /Шинээр болон нэмж хувьцаа бүртгүүлэхэд/

Маягт 2. Бүртгэлийн өргөдлийн маягт /Өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд/

Маягт 3. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл

Маягт 4. Андеррайтерийн мэдэгдэл

*Маягт 5. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад хүргүүлэх
мэдэгдэл*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компани /цаашид МХБ ТӨХК гэх/-ийн бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд шинээр болон нэмж гаргах үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах, арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах зэрэг бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Хувьцаа, өрийн хэрэгслээс бусад төрлийн үнэт цаас /үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэх мэт/-ны бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдох онцлог харилцааг нэмэлт буюу тусгай журмаар зохицуулна.
- 1.3. МХБ ТӨХК-д гаргах хадгаламжийн бичгийг бүртгэх, арилжихтай холбоотой харилцааг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/-ны “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай” журмаар зохицуулах ба уг журмын дагуу зөвшөөрөл авсан этгээд МХБ ТӨХК-д хүсэлт гаргасны үндсэн дээр хадгаламжийн бичиг бүртгүүлж болно.
- 1.4. Энэхүү журмыг хэрэгжүүлэгч нь МХБ ТӨХК байх ба хөрөнгийн биржид бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр төлөвлөж буй дотоод, гадаадын үнэт цаас гаргагч, түүний төлөөлөн удирдах зөвлөл, эрх бүхий албан тушаалтан, андеррайтер, бүртгэлийн үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Хууль журам

- 2.1. Энэхүү журам нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон СЗХ-ны зохицуулалтад нийцсэн, МХБ ТӨХК, Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас гаргасан холбогдох дүрэм журам, эрх зүйн акттай уялдсан байна.
- 2.2. Уул уурхай, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч, бусад онцлог салбар, чиглэлийн үнэт цаас гаргагчдыг бүртгэх нэмэлт журам, заавар гаргаж болно.
- 2.3. МХБ ТӨХК нь энэхүү журмын зохицуулалтыг тодруулах, хэрэглэхэд хялбар болгох зорилгоор гарын авлага, зөвлөмж, заавар гаргаж болно.
- 2.4. Энэхүү журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацаа, дагаж мөрдөх журмын талаарх МХБ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн шийдвэр нь СЗХ батламжилснаар хүчин төгөлдөр болно.

3 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тайлбар

- 3.1 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаар болон СЗХ-ны 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” /цаашид “Хорооны бүртгэлийн журам” гэх/-д зааснаар ойлгохоос гадна дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 3.1.1 **“Захирлын зөвлөлийн хурал”** МХБ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулсан захирлын зөвлөлийн хурал;
 - 3.1.2 **“Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах”** Эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэт цаас гаргагчийн зохион байгуулалтын хэлбэр, үнэт цаасны

- нэр, нэрлэсэн үнэ, тоо ширхэгт орсон өөрчлөлт, биржийн ангилал хооронд шилжих зэрэгтэй холбоотой бүртгэлийн үйл ажиллагаа;
- 3.1.3 “**Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрөл**” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т зааснаас СЗХ-ноос олгосон зөвшөөрлийг;
- 3.1.4 “**Тогтмол мэдээлэл хүргэх үүрэг бүхий этгээд**” гэж энэхүү журмын 18.4.5-д заасны дагуу үнэт цаасны арилжааны хэлцэл, гүйлгээний мэдээллийг үнэт цаас гаргагч компанид мэдээлэх үүрэгтэй компанийн эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой этгээдийг;
- 3.1.5 “**Өрийг хувьцаагаар солих төсөл**” гэж Компанийн тухай хуулийн 25-р зүйлд заасны дагуу хувьцаагаар солих өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг тусгасан төслийг;
- 3.1.6 “**Гадаад улсын үнэт цаас гаргагч**” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.4-т зааснаар СЗХ-ноос тогтоосон Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын хөрөнгийн биржийн жагсаалтад орсон гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, СЗХ болон МХБ ТӨХК-ийн тогтоосон шалгуурыг хангасан Монгол Улсын улсын бүртгэлд бүртгэгдээгүй, гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг;
- 3.1.7 “**Давхар бүртгэл**” /**Dual listing**/ гэж үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор компанийн үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан үнэт цаасыг нэгээс илүү биржид бүртгэхийг;
- 3.1.8 “**Хоёрдогч бүртгэл**”/**Cross/Secondary listing** / гэж компани нэмэлт хөрөнгө татах зорилгоор өөрийн хувьцаагаа дотоодын биржээс гадна өөр биржүүдэд бүртгүүлж, хувьцааг улс хооронд чөлөөтэй арилжих нөхцөлийг бий болгохыг;

4 дүгээр зүйл. Бүртгэлийн болон хяналтын албаны чиг үүрэг

- 4.1 Үнэт цаас бүртгүүлэх тухай МХБ ТӨХК-д ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, хянах, үнэт цаасыг ангилал хооронд шилжүүлэх, үнэт цаасыг бүртгэлээс хасах зэрэг үйл ажиллагааг Бүртгэлийн алба хэрэгжүүлэх ба албаны зүгээс гаргасан саналаа Захирлын зөвлөлийн хурал /цаашид ЗЗХ гэх/-д танилцуулна.
- 4.2 Энэхүү бүртгэлийн журмын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг Хяналтын алба энэ журам болон Хяналт шалгалтын журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 4.3 Шаардлагатай тохиолдолд журмын 4.2-т заасан үйл ажиллагаанд Бүртгэлийн алба оролцож болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

5 дугаар зүйл. Үнэт цаас бүртгэх үе шат

- 5.1. Үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэх ажиллагаа нь дараах үе шаттай байна:
- 5.1.1. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргах,
- 5.1.2. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авч хянах,
- 5.1.3. Үнэт цаасыг бүртгэх,
- 5.1.4. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах,

- 5.2. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргахад бэлтгэх талаарх Хорооны бүртгэлийн журмын аравт заасан холбогдох зохицуулалт нь МХБ ТӨХК-ийн бүртгэлд бэлтгэхэд нэгэн адил хамаарна.

6 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргах

- 6.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа СЗХ-ны болон биржийн бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлөө нэгэн зэрэг СЗХ болон МХБ ТӨХК-д гаргаж болно.
- 6.2. Үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл, үнэт цаасны танилцуулгад Хорооны бүртгэлийн журмын 13.3.1-д зааснаар үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга /эсхүл ерөнхий нягтлан бодогч/, андеррайтер хийсэн зохицуулалттай этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.
- 6.3. Үнэт цаас бүртгүүлэхийг хүссэн өргөдөл гаргахдаа дараах бүрдүүлбэрийг хангасан баримт бичгийг Хавсралт 1-ийн дагуу гаргаж, баталгаажуулан ирүүлнэ.
- 6.3.1. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл /Маягт 1- Маягт 2/,
- 6.3.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр,
- 6.3.3. Үнэт цаас бүртгэхийг зөвшөөрсөн тухай СЗХ-ны шийдвэр,
- 6.3.4. Зохих журмын дагуу бэлтгэгдэн, СЗХ-нд бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулга,
- 6.3.5. Андеррайтерийн байгууллагын болон бусад шаардлагатай мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт, дүгнэлт,
- 6.3.6. Үнэт цаас гаргагчийн болон андеррайтерийн мэдэгдэл ба баталгаа /Маягт 3-Маягт 4/
- 6.3.7. Журмын 24.2-т заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт,
- 6.3.8. Энэ журам, түүний хавсралтад заасан бусад нэмэлт баримт бичгүүд,
- 6.4. МХБ ТӨХК болон СЗХ-нд үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдлөө нэгэн зэрэг гаргасан компанийн хувьд энэ журмын 6.3.3-т заасан баримт бичгийг СЗХ-ноос бүртгэх тухай шийдвэр гарсны дараа буюу арилжаа эхлэхээс өмнө ирүүлэх бөгөөд 6.3.4-т заасан танилцуулгад өөрчлөлт орсон бол мөн хамтад нь ирүүлнэ.
- 6.5. Баримт бичгийг журамд заасан дарааллын дагуу эмхтгэн Хорооны бүртгэлийн журмын арван гуравт заасан агуулга, хэлбэрийн шаардлагад бүрэн нийцүүлсэн байна.
- 6.6. Өргөдөл гаргагч гадаадын хуулийн этгээд нь энэ журамд заасан баримт бичгийг боловсруулахдаа Хорооны бүртгэлийн журмын 6.12, 6.13-д заасан шаардлагыг хангасан байна.
- 6.7. Засгийн газрын өрийн хэрэгсэл, Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасны үндсэн дээр үнэт цаасаа нийтэд санал болгон гаргахад журмын 6.3.4 - 6.3.6 –т заасан баримт бичгийг ирүүлэхгүй байж болно.

7 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авч хянах

- 7.1. МХБ ТӨХК нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өргөдөл, энэ журмаар тогтоосон баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор хянаж, бүртгэлийн шалгалт хийнэ.
- 7.2. Энэхүү журам болон МХБ ТӨХК-иас тогтоосон шалгуурыг хангаж буй эсэх талаар хийгдсэн шалгалтын тайланг ЗЗХ-аар хэлэлцүүлж, ЗЗХ-ын саналыг үндэслэн үнэт цаасыг бүртгэх эсэх тухай шийдвэрийг МХБ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар гаргана.
- 7.3. Хянан шалгах хугацааг өргөдөл гаргагчийн баримт материал нь зохих шаардлагыг хангаж, бүрэн бүрдсэн өдрөөс эхлэн тооцох ба шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тухайн компанийн удирдлагаас үнэт

цаас, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар тодруулга, нэмэлт баримт бичиг гаргуулан авч болно.

- 7.4. Энэ журмын 7.2-д заасан шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг, аудитын болон үнэлгээний зэрэг бусад хөндлөнгийн байгууллага, мэргэжилтний дүгнэлт гаргуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл хоногоор сунгана.
- 7.5. МХБ ТӨХК нь хууль, журамд тодорхойлсон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор үнэт цаас гаргагч, холбогдох бусад этгээдээс шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргуулан авч болох ба тухайн мэдээллийг олон нийтэд мэдээлэхийг үнэт цаас гаргагч болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс шаардаж болно.

8 дугаар зүйл. Үнэт цаас бүртгэх

- 8.1. МХБ ТӨХК нь өргөдөл гаргагчийн үнэт цаасыг бүртгэхдээ энэхүү журмаар тогтоосон бичиг баримтын бүрдэл, бүртгэлийн шалгуур хангасан эсэхийг хянаж, шаардлага хангасан үнэт цаасыг бүртгэнэ.
- 8.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу МХБ ТӨХК нь тухайн үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэсэн тухай болон арилжааг эхлүүлэх бэлтгэлийг хангасан тухай тодорхойлолтыг, үнэт цаас гаргагч нь арилжаа эхлүүлэх тухай хүсэлтийг тус тус СЗХ-нд бичгээр мэдэгдсэний үндсэн дээр үнэт цаасны анхдагч зах зээлд уг үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг СЗХ олгоно.
- 8.3. Зөвхөн СЗХ болон МХБ ТӨХК-ийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасанд олон нийтэд арилжих зөвшөөрөл олгоно.
- 8.4. Үнэт цаасыг МХБ ТӨХК-д бүртгэж, арилжих зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч буй баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан аливаа хохирлыг МХБ ТӨХК хариуцахгүй.
- 8.5. МХБ ТӨХК нь үнэт цаас нь бүртгэгдсэн үнэт цаас гаргагчтай "Бүртгэлийн гэрээ" байгуулж, үнэт цаас бүртгэсэн, бүртгэлд өөрчлөлт орсон, бүртгэлээс хасагдсан тухай мэдэгдлийг маягт 5-ын дагуу Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.
- 8.6. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан хувьцаанд үсгэн код, үнэт цаасны нэр олгож бүртгэнэ.
- 8.7. Хувьцааны үсгэн код нь тухайн үнэт цаас гаргагч компанийн нэрийг илэрхийлэх 3-аас доошгүй 4-өөс илүүгүй латин үсгээр тэмдэглэгдэнэ.
- 8.8. Өрийн хэрэгслийг үнэт цаасны нэрээр бүртгэх ба нэрэнд өрийн хэрэгслийн хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөгдөх хугацаа зэргийг тусгана.
- 8.9. Үнэт цаасны код, нэрийг давхардуулж үл болно.
- 8.10. Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш 6 сарын дотор үнэт цаасаа олон нийтэд санал болгож арилжаагүй бол түүнийг МХБ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр бүртгэлээс хасч, хариу мэдэгдэл хүргүүлнэ.

9 дүгээр зүйл. Үнэт цаас бүртгэхээс татгалзах

- 9.1. МХБ ТӨХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.10, Хорооны бүртгэлийн журмын 19.1-д зааснаас гадна МХБ ТӨХК-иас тогтоосон тухайн ангиллын шалгуурыг хангаагүй гэдэг үндэслэлээр үнэт цаасыг бүртгэхээс татгалзаж, үндэслэл бүхий хариуг үнэт цаас гаргагчид бичгээр мэдэгдэнэ.
- 9.2. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангах боломжтой гэж МХБ ТӨХК үзвэл шалгуурыг 6 сар хүртэлх хугацаанд хангах талаар тодорхой чиглэл өгч, бүртгэлийн ажиллагааг уг хугацаанд хойшлуулах шийдвэр гаргаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ АРГА

10 дугаар зүйл. Үнэт цаас бүртгүүлэх арга

10.1. Хувьцааг бүртгэлийн дараах аргаар бүртгүүлнэ:

10.1.1. Өөрийн эзэмшлийн хувийг санал болгох-Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшихээр захиалга өгсөн этгээд нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа олон нийтэд худалдахаар санал болгож болно. Энэ тохиолдолд компани нь нэмэлт хөрөнгө оруулалт татахгүй.

10.1.2. Хаалттай хүрээнд санал болгох-Үнэт цаасыг олон нийтэд санал болгохоос өмнө андеррайтерийн байгууллага болон бусад этгээдэд хаалттай хүрээнд нэр заан эзэмшүүлж болно.

10.1.3. Тэргүүн ээлжид давуу эрхтэйгээр санал болгох

10.1.3.1. Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 25.6, 34.2 болон 38 дугаар зүйлд зааснаар одоогийн хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжид давуу эрхтэйгээр санал болгох тохиолдолд андеррайтераар дамжуулна.

10.1.3.2. Хэрэв тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй гаргаж байгаа хувьцааны үнийн дүн нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон зах зээлийн үнэлгээг 50 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлж байвал дараах нөхцөлийг хангах шаардлагатай:

10.1.3.2.1. Тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй үнэт цаас гаргах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байх,

10.1.3.2.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэн, тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлэх эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх арга зам, уг эрхээ эдлэх хугацаа, энэ хугацаанд эрхээ хэрэгжүүлээгүйгээс гарах үр дагаврын талаар танилцуулга, мэдээлэлд тодорхой тусгасан байх,

10.1.4. Нээлттэй хүрээнд санал болгох-Нээлттэй хүрээнд санал болгож буй үнэт цаасыг одоогийн эзэмшиж байгаа хувь хэмжээнээс үл хамааран хэн ч худалдаж авах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байх тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлсэн, эсхүл энэ тухай тус компанийн дүрэмд заасан байхаас гадна андеррайтертай гэрээ байгуулсан байна.

10.1.5. Хуримтлагдсан ашиг, нэмж төлөгдсөн капитал, ногдол ашиг, нөөц хөрөнгө, өр төлбөр зэргийг хувьцаанд шилжүүлэх замаар хувьцаа санал болгох

10.1.6. Компани болон түүний хувьцааг нэгтгэх, нийлүүлэх, хуваах зэрэг арга замаар хувьцаа санал болгох

10.2. Өрийн хэрэгсэл бүртгүүлэх тохиолдолд бүртгэлийн дараах арга хэлбэрийг ашиглаж болно:

10.2.1. Өрийн хэрэгсэл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн өрийн хэрэгслийг санал болгох

10.2.2. Хаалттай хүрээнд санал болгох

10.2.3. Нээлттэй хүрээнд санал болгох

10.3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргах өрийн хэрэгсэл болон Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан өрийн хэрэгслийн бүртгэлийг СЗХ-ны зөвшөөрлийн дагуу МХБ ТӨХК-д бүртгэн арилжиж болно.

10.4. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн гаргасан өрийн хэрэгсэл, гадаадын валютаар гаргасан өрийн хэрэгсэл, гадаадын биржид урьд нь гаргасан өрийн хэрэгсэл буюу

олон улсын өрийн хэрэгсэл зэрэгт энэхүү журам хамаарахгүй бөгөөд тусгай нөхцөл үйлчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

11 дүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн шалгуур

- 11.1. Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д бүртгүүлэхэд, бүртгэлтэй байх хугацаанд энэ журам болон МХБ ТӨХК-иас тавигдах бусад шалгуурыг хангаж ажиллана.
- 11.2 Шинээр ба нэмж үнэт цаас бүртгүүлэхэд, нэгдэж, нийлэх ба хуваах, тусгаарлах замаар үнэт цаас болон компани бүртгүүлэхэд энэ бүлэгт заасан тухайн ангиллын шалгуурыг хангасан байна.
- 11.3. Хөрөнгийн биржийн бүртгэлд хувьцааг тус бүрийн онцлог шалгуур бүхий “I”, “II”, “III” гэсэн гурван ангиллаар бүртгэнэ.

12 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуур

- 12.1. Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч нь дараах шалгуур хангасан байна:
 - 12.1.1. Өргөдөл гаргахаас өмнөх 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх,
 - 12.1.2. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д заасан стандартын дагуу бэлтгэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3-т зааснаар СЗХ-нд бүртгүүлсэн хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдөх зарчим /GAAP/-ын аль нэгээр тайлагнасан байх,
 - 12.1.3. Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд 10 000 000 000 /арван тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой, 1 000 000 000 /нэг тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажилласан байх,
 - 12.1.4. Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх, хэрэв өртэй тохиолдолд өр зээлийн талаар үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй мэдээлсэн байх,
 - 12.1.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай байх ба сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагад эсхүл гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд, сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх,
 - 12.1.6. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх,
 - 12.1.7. Үнэт цаасыг нийтэд санал болгохдоо андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх /цаашид андеррайтертай байх, андеррайтераар дамжуулах гэх/
- 12.2 Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна:
 - 12.2.1 Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр тус компанийн зах зээлийн үнэлгээ нь 10 000 000 000 /арван тэрбум/ төгрөгөөс дээш байх,
 - 12.2.2 Үнэт цаас гаргагчийн гаргах нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх,

- 12.2.3 Үнэт цаас нь хөрөнгийн бирж дээр 2-оос доошгүй жил арилжигдсан байх,
- 12.2.4 Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх,

13 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуур

- 13.1. Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуур хангасан байна.
 - 13.1.1 Энэхүү журмын 12.1.4, 12.1.7-т заасан шалгуурыг хангасан байх,
 - 13.1.2 Өргөдөл гаргахаас өмнөх 2-оос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх,
 - 13.1.3 Өргөдөл гаргахаас өмнөх 2-оос доошгүй жилийн санхүүгийн тайланг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д заасан стандартын дагуу бэлтгэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3-т зааснаар СЗХ-нд бүртгүүлсэн хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдөх зарчим /GAAP/-ын аль нэгээр тайлагнасан байх,
 - 13.1.4 Компани бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй байх,
 - 13.1.5 Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах,
 - 13.1.6 Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай байх,
- 13.2 Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна:
 - 13.2.1 Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр тус компанийн зах зээлийн үнэлгээ нь 1 000 000 000 /нэг тэрбум/ төгрөгөөс дээш байх,
 - 13.2.2 Үнэт цаас гаргагчийн гаргах нийт хувьцааны 15-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх,
 - 13.2.3 Энэхүү журмын 12.2.4-т заасан шалгуурыг хангах,

14 дүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн III ангиллын нөхцөл, шалгуур

- 14.1. Хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах нөхцөл, шалгуур хангасан байна:
 - 14.1.1 Энэхүү журмын 12.1.4, 12.1.7, 13.1.6-т заасан шалгуурыг хангасан байх,
 - 14.1.2 Хувьцааны зах зээлийн үнэлгээ нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан МХБ ТӨХК-иас тухай бүр тогтоосон шаардлагыг хангасан байх,
 - 14.1.3 Хувьцааны бүртгэлийн III ангилалд хөрөнгийн бирж дээр арилжаалагдсан эсхүл үйл ажиллагаа явуулсан байвал зохих хугацааны болон үнэт цаасны олон нийтийн эзэмшилд байх доод хэмжээг тогтоогоогүй, хувьцаагаа энэ журмын 14.1.4-т заасан этгээдэд санал болгон арилжаалдаг, шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, жижиг, дунд хэлбэрийн компани, эсхүл хайгуулын, ашиглалтын лиценз бүхий уул уурхайн компаниуд хувьцаагаа арилжиж болно.
 - 14.1.4 Хувьцааны бүртгэлийн III ангиллын үнэт цаасыг Хорооны бүртгэлийн журмын 2.1.7, 2.1.8-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаална.
 - 14.1.5 Хувьцааны бүртгэлийн III ангиллын үнэт цаасыг энэ журмын 14.1.4-т заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан

авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаас нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бичгээр мэдэгдсэн байна.

15 дугаар зүйл. Бүртгэлийн шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх

- 15.1 Үнэт цаас гаргагч, түүнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээд нь энэхүү журмаар тогтоосон хувьцааны ангиллын шалгуур болон өрийн хэрэгслийн шалгуураас чөлөөлүүлэх буюу хөнгөлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтээ Хорооны бүртгэлийн журмын арван нэгд зааснаар СЗХ болон МХБ ТӨХК-д гаргах эрхтэй.
- 15.2 Энэ журмын 15.1-д заасан СЗХ-ны ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаалаар тухайн үнэт цаас гаргагч буюу үнэт цаасны хувьд тодорхой нөхцөл хангахыг үүрэг болгох буюу тийнхүү үүрэг болгохгүйгээр энэхүү журамд заасан бүртгэлийн шалгуурыг хөнгөлөх буюу чөлөөлж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

16 дугаар зүйл. Өрийн хэрэгслийн шалгуур

- 16.1 МХБ ТӨХК-д өрийн хэрэгсэл бүртгүүлэхээр өргөдөл гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна:
 - 16.1.1 Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангасан байх,
 - 16.1.2 Үнэт цаас гаргагч, түүний өрийн хэрэгсэл нь энэхүү журмын 12 дугаар зүйл буюу хувьцааны бүртгэлийн I ангилалд үнэт цаас бүртгүүлэхэд тавигдах шалгуурын 12.2.2, 12.2.3-р заалтаас бусад шалгуур үзүүлэлтийг хангасан байх,
 - 16.1.3 Хэрэв бүртгүүлэх өргөдөл гаргах үед тухайн үнэт цаас гаргагч нь энэ журмын 16.1.2-т заасан шалгуурыг хангахааргүй бол дараах шаардлагын аль нэгийг хангасан байна:
 - 16.1.3.1 Үнэт цаас гаргагч нь компанийн үндсэн үйл ажиллагааг 3-аас доошгүй жил тасралтгүй эрхэлсэн байх ба өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж чадах хангалттай хэмжээний барьцаа хөрөнгөтэй байх,
 - 16.1.3.2 Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан байх,
 - 16.1.3.3 Олон улсын болон дотоодын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ буюу санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон, зэрэглэл өндөртэй байх,
 - 16.1.4 Өрийн хэрэгслийг МХБ ТӨХК-д бүртгүүлэх тохиолдолд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх шаардлагатай боловч тухайн үнэт цаасыг санал болгож буй цар хүрээ, гаргаж буй этгээдийн онцлог зэргээс хамаарч шаардахгүй байж болно.
 - 16.1.5 Хөрвөх өрийн хэрэгслийн хувьд хөрвөх хувьцаа нь хөрөнгийн биржид бүртгэлтэй байх ба Монгол Улсын Компанийн тухай хуулийн 39-р зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

16.1.6 Өрийн хэрэгсэл худалдан авагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, тэдэнд эрсдэл учрах магадлалтай гэж үзвэл эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн барьцаагаар баталгаажуулахыг, эсхүл гуравдагч хөндлөнгийн этгээдээр баталгаа гаргуулахыг тус тус шаардаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

17 дугаар зүйл. Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг

- 17.1 Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааварт туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.
- 17.2 Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаанд энэхүү журамд заасан өрийн хэрэгслийн болон хувьцааны зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллана.
- 17.3 Санхүүгийн тайлан балансыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн үнэн зөв гаргаж, зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулна.
- 17.4 Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон ногдол ашиг тараах зэрэг компанийн хэрэгжүүлэх ажиллагааг /corporate action/ зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэрийг баримтлах бөгөөд уг ажиллагааг өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулна.
- 17.5 МХБ ТӨХК-ийн зүгээс хийгдэх төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын ажлын хүрээнд МХБ ТӨХК-ийн холбогдох албан тушаалтанг компанийн байранд саадгүй нэвтрүүлэх, шаардлагатай баримт бичиг, мэдээ мэдээллийг үнэ төлбөргүй гарган өгөх үүрэгтэй.
- 17.6 Үнэт цаастай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хувьцаа эзэмшигч, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий үнэт цаас хариуцсан ажилтантай байна.

18 дугаар зүйл. Мэдээлэл ил тод болгох

- 18.1 Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаар, мөн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээллийг хууль болон СЗХ, МХБ ТӨХК-ийн журам, зааварт тусгасан хугацаанд зохих шаардлагын дагуу нийтэд болон МХБ ТӨХК-д мэдээлнэ.
- 18.2 МХБ ТӨХК нь энэхүү журамд тусгасан мэдээлэл буюу үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээллийг МХБ ТӨХК-д ирүүлэх, олон нийтэд хүргэх хугацаа, мэдээллийн агуулга, мэдээллийн төрөл зэргийг тодорхойлсон тусгай журам, заавар гаргаж болно.
- 18.3 Үнэт цаас гаргагч нь үнэт цаас эзэмшигч болоод бусад талуудад мэдээллийг ил тод, үнэн бодитой, шуурхай хүргэх үүднээс компанийн албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулна.
- 18.4 Нийтэд зайлшгүй хүргэх мэдээллийн төрлийг энэхүү журамд дараах байдлаар тодорхойлж байна:
 - 18.4.1 Жилийн санхүүгийн тайлан
 - 18.4.1.1 Үнэт цаас гаргагч нь аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт тогтоосон хугацаанд МХБ ТӨХК-д ирүүлж, олон нийтэд мэдээлнэ.
 - 18.4.1.2 Жилийн санхүүгийн тайлан нь дараах шаардлагуудыг хангасан байна:
 - 18.4.1.2.1 Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн гаргасан байх,

- 18.4.1.2.2 Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, эсхүл өөр ижил төстэй стандартаар аудит хийлгэсэн байх,
- 18.4.1.2.3 Үнэт цаас гаргагчийн тухайн жилийн үйл ажиллагааны болон компанийн засаглалын тайланг, СЗХ-ноос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг жилийн тайлантай хамт мэдээлнэ.
- 18.4.2 Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан
 - 18.4.2.1 Үнэт цаас гаргагч нь хагас жилийн санхүүгийн тайланг стандартын дагуу бэлтгэн гаргаж, МХБ ТӨХК-д тогтоосон хугацаанд ирүүлнэ.
 - 18.4.2.2 Харин улирал тутмын санхүүгийн тайланг сайн дурын үндсэн дээр МХБ ТӨХК-д ирүүлэх ба олон нийтэд нийтэлж болно.
- 18.4.3 Компанийн үйл явдлын хуанли
 - 18.4.3.1 Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлсэн даруй болон бүртгүүлснээс хойш тогтоосон хугацаанд тухайн жилд төлөвлөсөн үйл явдлын хуанли бэлтгэж МХБ ТӨХК-д ирүүлэх ба өөрчлөлт орсон тухай бүрт мэдэгдэнэ.
 - 18.4.3.2 Компанийн үйл явдлын хуанлид хувьцаа эзэмшигчдийн хурлын тов, жилийн болон улирлын санхүүгийн тайлан, бусад мэдээг нийтлэх хугацаа гэх мэт хувьцаа эзэмшигчдэд зайлшгүй хүргэх үйл явдлын товын талаарх мэдээллийг оруулна.
- 18.4.4 Үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээлэл
 - 18.4.4.1 Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх аливаа мэдээллийг МХБ ТӨХК-д бичгээр болон цахим хэлбэрээр, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. /Үнэ ханш, арилжааны хэмжээнд нөлөөлөх мэдээлэл гэдэгт үнэт цаасны зах зээлийн ханшийг огцом өөрчлөх боломжтой мэдээллийг ойлгоно./
 - 18.4.4.2 Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд нөлөөлөх үйл явдлыг мэдсэн даруй буюу дараагийн өдрийн арилжаа эхлэхээс 1 цагаас илүүгүй хугацааны өмнө МХБ ТӨХК-д мэдэгдэнэ.
 - 18.4.4.3 Үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд нөлөөлөх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж, зах зээлийн бүх оролцогчдыг адил тэгш боломжоор хангана.
 - 18.4.4.4 Үнэт цаасны үнэ ханштай холбоотой мэдээллийн нууцыг үнэт цаас гаргагч тухайн мэдээллийг олон нийтэд мэдээлэх хүртэл чанд хадгална. Мэдээлэл алдагдсан тохиолдолд, үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээллийг нийтэд мэдээлэх журмын дагуу нэн даруй зах зээлд мэдээлнэ.
- 18.4.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчид зэрэг тогтмол мэдээлэл хүргэх үүрэг бүхий этгээдтэй холбоотой мэдээлэл
 - 18.4.5.1 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй тухайн компанийн болон бусад компанийн хувьцааны хувь хэмжээ, тоо ширхэгт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д мэдэгдэнэ.
 - 18.4.5.2 Тогтмол мэдээлэл хүргэх үүрэг бүхий этгээд нь тухайн үнэт цаас гаргагч компанийн үнэт цаастай холбоотой хийгдсэн аливаа хэлцэл бүрийн мэдээллийг үнэт цаас гаргагчид ажлын 1 хоногт багтаан мэдэгдэнэ.
 - 18.4.5.3 Тогтмол мэдээлэл хүргэх үүрэг бүхий этгээдээс үнэт цаас гаргагчид хүргэх мэдэгдэлд дараах мэдээллийг агуулсан байна:
 - 18.4.5.3.1 Тогтмол мэдээлэл хүргэх шаардлагатай этгээдийн нэр, /хувь хүн, хуулийн этгээд/

- 18.4.5.3.2 ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүн, гүйцэтгэх удирдлага, хувь эзэмшигч гэх зэрэг албан тушаалын байдал,
 - 18.4.5.3.3 Хэлцлийн төрөл /Авсан, зарсан талаар/
 - 18.4.5.3.4 Хэлцэл хийгдсэн хэлбэр /үнэт цаасны арилжаагаар эсвэл бусад хэлбэрээр/,
 - 18.4.5.3.5 Үнэт цаасны төрөл, тоо хэмжээ,
 - 18.4.5.3.6 Үнэт цаасны нэр, код,
 - 18.4.5.3.7 Хэлцлийн нийт үнийн дүн,
 - 18.4.5.3.8 Хэлцэл хийсэн огноо,
 - 18.4.5.3.9 Мэдэгдэл хүргүүлсэн огноо,
 - 18.4.5.4 Үнэт цаас гаргагч нь журмын 18.4.5.3-д заасан мэдээллийг энэ тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэн даруй МХБ ТӨХК-д бичгээр болон цахим хэлбэрээр мэдэгдэх ба 18.4.5.3.1-ээс бусад мэдээллийг олон нийтэд хүргэнэ.
 - 18.4.5.5 Үнэт цаас гаргагч болон МХБ ТӨХК нь хүлээж авсан мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгалах ба тодорхой хугацаанд нийтэд ил тод байлгана.
- 18.4.6 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчидтэй холбоотой мэдээлэл
- 18.4.6.1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт орох тухай бүр нь үнэт цаас гаргагч болон МХБ ТӨХК-д мэдэгдэнэ.
 - 18.4.6.2 Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д ирүүлсэн болон олон нийтэд түгээсэн мэдээллийн үнэн зөв, бодитой, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах ба түүнээс үүдэх хариуцлагыг хүлээнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ГАДААД УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН

ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ

19 дүгээр зүйл. Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг бүртгэх

- 19.1 Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18-р зүйлд заасны дагуу СЗХ-ноос хүлээн зөвшөөрсөн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, СЗХ болон МХБ ТӨХК-ийн тогтоосон шалгуурыг хангасан гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд /цаашид гадаад улсын үнэт цаас гаргагч гэх/ нь МХБ ТӨХК-д үнэт цаасаа бүртгүүлэн, арилжихаар өргөдөл гаргаж болно.
- 19.2 Гадаад улсын үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа давхар болон хоёрдогч бүртгэлээр МХБ ТӨХК-д хадгаламжийн бичиг гаргах замаар бүртгүүлж болно.
- 19.3 Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд МХБ ТӨХК-д бүртгүүлэх ажиллагаа болон бүртгэгдсэнээс хойш хэрэгжүүлэх арга хэмжээ нь дотоодын үнэт цаас гаргагчийн нэг адил нөхцөлтэй байх ба журмын дагуу баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх, журмаар тавигдах шалгуурыг хангах, үйлчилгээний хөлс төлөх, хариуцлага хүлээх заалтууд нэгэн адил үйлчилнэ.
- 19.4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангахад болон дотоодын зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан онцгой тохиолдолд гадаад улсын үнэт цаас гаргагчдад нэмэлт шалгуур тогтоож болно.
- 19.5. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь Монгол Улсын болон тухайн гадаад улсын хууль эрх зүйн зөрүүтэй байдлын талаар, түүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэлийн талаар харьцуулсан мэдээллийг үнэт цаасны танилцуулгад тусгаж, олон нийтэд мэдээлнэ.

- 19.6. Давхар болон хоёрдогч бүртгэл хийлгэхээр өргөдөл гаргагч нь Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр хувьцаагаа бүртгүүлэн арилжина. Өргөдөл гаргагч нь эрх бүхий этгээдээс хүлээн зөвшөөрөгдсөн бол гадаад валютаар үнэт цаасаа гаргаж болно.
- 19.7. МХБ ТӨХК, гадаад орны бирж хооронд үнэт цаасны арилжааны болон бусад зохицуулалтын систем байхгүй бол бирж хооронд харилцан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр зохицуулалт хийж болно.
- 19.8. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь журмын 17.4-т заасан компанийн хэрэгжүүлэх ажиллагааг /corporate action/ зохион байгуулахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн үнэт цаасны хадгаламжийн болон кастодианы байгууллагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлнэ.
- 19.9. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь давхар бүртгүүлсэн биржүүдэд болон үнэт цаас эзэмшигч нарт хүргэх мэдээллийг нэгэн зэрэг түгээх шаардлагатай ба МХБ ТӨХК-д ирүүлэх мэдээллийг Монгол ба англи хэл дээр бэлтгэн ирүүлнэ.
- 19.10. Давхар бүртгэгдсэн гадаад улсын биржид тухайн үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт орсон, зөрчил дутагдал, хариуцлагын арга хэмжээ авагдсан, бүртгэлээс хасагдсан зэрэг тохиолдолд үнэт цаас гаргагч нь нэн даруй МХБ ТӨХК-д мэдэгдэнэ.
- 19.11. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д бүртгэлтэй байх хугацаандаа үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий байгууллагатай харилцах албан ёсны төлөөлөгчийг томилон Монгол Улсад ажиллуулахыг МХБ ТӨХК-иас шаардаж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

20 дугаар зүйл. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

- 20.1 Хорооны бүртгэлийн журмын хорьд заасан үндэслэл, журмаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай СЗХ-ны шийдвэрийн дагуу МХБ ТӨХК-ийн бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 20.2 Энэ журмын 20.1-д зааснаас гадна дор дурдсан үндэслэлээр МХБ ТӨХК-ийн бүртгэлд өөрчлөлт оруулж болно.
 - 20.2.1 Үнэт цаасны нэр, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хэлбэр өөрчлөх тухай шийдвэр гарсан,
 - 20.2.2 Үнэт цаасыг МХБ ТӨХК-ийн хувьцааны бүртгэлийн нэг ангиллаас нөгөө ангилалд өгсүүлж буюу бууруулж бүртгэх,
- 20.3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг ЗЗХ-ын санал, дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирал гаргана.

21 дүгээр зүйл. Бүртгэлийн ангилал өгсүүлж бүртгэх

- 21.1. Хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын хугацаанд үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан нь хууль, журам зөрчиж, хариуцлага хүлээж байгаагүй бол II ангилалд бүртгэлтэй байгаа үнэт цаас гаргагч энэхүү журмаар тогтоосон I ангиллын, III ангилалд бүртгэлтэй байгаа үнэт цаас гаргагч энэхүү журмаар тогтоосон II ангиллын шалгуурыг тус тус бүрэн бүрэн хангасан гэдэг үндэслэлээр ангилал өгсөж бүртгүүлэхээр МХБ ТӨХК-д хүсэлтээ гаргаж болно.
- 21.2. Хүсэлтийг Хавсралт 1-д заасан өргөдлийн маягтын дагуу гаргаж, бүртгэлийн шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хамт бүрдүүлэн ирүүлнэ.
- 21.4. Энэ журмын 21.1-д заасан хүсэлтийг Бүртгэлийн алба шалгаж, ЗЗХ-аар хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ. Уг тушаалд энэ журмын 21.5-д заасан мэдээллийг тусгасан байна.

- 21.5. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн ангилал өгсүүлж бүртгэх тухай Гүйцэтгэх захирлын тушаал гарсан даруй буюу ажлын нэг өдөрт багтаан СЗХ болон олон нийтэд мэдэгдэнэ.
- 21.6. СЗХ болон олон нийтэд хүргэх бүртгэлийн ангилал өгсөж бүртгүүлсэн тухай мэдэгдэлд дараах мэдээллийг тусгасан байна:
- 21.1.1 Бүртгэлийн ангилал өгсөж бүртгүүлэх болсон шалтгаан, үндэслэл
 - 21.1.2 Өгсөж бүртгүүлэх тухайн ангиллын шалгуурыг хангасан болохыг батлах баримт,
 - 21.1.3 Шинэ ангилалд шилжих хугацаа буюу тухайн ангиллаар үнэт цаас арилжиж эхлэх огноо,
 - 21.1.4 Шинэ ангилалд бүртгэсэн үнэт цаасны нэр, код,
 - 21.1.5 МХБ ТӨХК-ээс мэдэгдэлд тусгах шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл,
- 21.7 Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь бүртгэлийн ангилал өгсөж бүртгүүлсэн тохиолдолд өмнө ангилалд бүртгэлтэй байсан хөрвөх хувьцаа хэлбэрийн үнэт цаас, түүнтэй төстэй эрхүүд, опцион зэрэг нь нэгэн зэрэг ангилал өгсөж бүртгэгдэнэ.

22 дугаар зүйл. Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэх

- 22.1 Энэхүү журмаар тогтоосон, одоо бүртгэлтэй байгаа I ангиллын шалгуураа бүрэн хангахгүй болсон хэдий ч II ангиллын шалгуурыг хангаж байгаа, мөн одоо бүртгэлтэй байгаа II ангиллын шалгуураа бүрэн хангахгүй болсон хэдий ч III ангиллын шалгуурыг хангаж байгаа үнэт цаас гаргагчийг МХБ ТӨХК-ийн санаачлагаар, түүнчлэн тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар бүртгэлийн ангилал уруудаж бүртгүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн бүртгэлийн ангиллыг бууруулж бүртгэнэ.
- 22.2 Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэх асуудлыг МХБ-ийн ЗЗХ-аар хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 22.3 Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэхэд энэ журмын 21.4, 21.5-д заасан олон нийтэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалт нэгэн адил хамаарна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

23 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах

- 23.1 Үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаасны арилжааг зогсоолгох болон үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлт гаргаж болох ба энэ тохиолдолд МХБ ТӨХК-иас тавих нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан байна.
- 23.2 Журмын 23.1-д заасан хүсэлтэд дараах мэдээллийг агуулсан байна:
- 23.2.1 Үнэт цаас гаргагчийн нэр,
 - 23.2.2 Үнэт цаасны талаарх мэдээлэл, /код, тоо хэмжээ, төрөл гэх мэт/
 - 23.2.3 Хүсэлт гаргах болсон шалтгаан, үндэслэл тайлбар ба нотлох баримт бичиг,
 - 23.2.4 Хууль болон компанийн дүрэмд үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болохыг нотлох баримт,
 - 23.2.5 Үнэт цаасны арилжааг зогсоох болон бүртгэлээс хасуулах огноо,
 - 23.2.6 Хэрэв тодорхой нөхцөл, шаардлага тавьж үнэт цаасны арилжааг зогсоох болон хасуулах бол тэр тухай мэдээлэл,

- 23.2.7 Үнэт цаас гаргагч нь бүртгэлээс хасуулахыг хүсч байгаа тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрийн төлөөлөгчдөд хүргэсэн талаар нотлох баримт,
 - 23.2.8 Компанийн тухай хуулийн 38, 53-р зүйлд заасан нөхцөл шаардлага бүрдсэн бол тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар, хувьцаа эзэмшигчдээс санал, гомдол гарсан эсэх талаар мэдээлэл, баримт материал,
 - 23.2.9 Үнэт цаас гаргагчийн уг асуудлыг хариуцан ажиллаж байгаа этгээдийн нэр, харилцах утас, хаяг,
 - 23.2.10 Өрийн хэрэгслийн хувьд үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдсөн эсэх талаарх зохих байгууллага, эрх бүхий этгээдийн тодорхойлолт,
 - 23.2.11 Өрийн хэрэгсэл гаргагчийн хувьд бүртгэлээс хасуулах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар урьдчилан хэлэлцүүлж, зөвшөөрөл авахыг шаардахгүй байж болно.
- 23.3 Үнэт цаас гаргагч нь журмын 23.1-д заасны дагуу гаргасан хүсэлтээсээ МХБ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэр гаргахаас өмнө татгалзаж болно.
- 23.4 МХБ ТӨХК-иас биржийн арилжаа, хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзсэний үндсэн дээр, үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу үнэт цаасны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах шийдвэр гаргана.
- 23.5 МХБ ТӨХК нь өөрийн санаачлагаар дараах тохиолдолд үнэт цаасны арилжааг зогсооно:
- 23.5.1 Бүртгэлтэй байх хугацаандаа тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй,
 - 23.5.2 Үнэт цаас нь сүүлийн 1 жилд огт арилжигдаагүй ба үнэт цаасны хөрвөх чадвар алдагдсан,
 - 23.5.3 Энэ журмаар тогтоосон тухайн ангиллын шалгуурыг хангахгүй болсон бөгөөд бүртгэлийн ангиллыг бууруулж бүртгэхийг сануулах зорилгоор,
 - 23.5.4 Давхар бүртгэлтэй биржийн бүртгэлээс тухайн үнэт цаас нь түр буюу бүр мөсөн хасагдсан,
 - 23.5.5 Өрийн хэрэгслийн хувьд үндсэн болон хүүгийн төлбөр хугацаандаа төлөгдөхгүй байгаа,
 - 23.5.6 Үнэт цаас гаргагчийн хувьд татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгч буюу эрх хүлээн авагч томилогдсон,
 - 23.5.7 Хууль, журамд заасан бусад үндэслэлээр.
- 23.6 Үнэт цаасны арилжааг зогсоох ба бүртгэлээс хасах асуудлыг МХБ ТӨХК-ийн ЗЗХ-ын саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 23.7 Үнэт цаасны арилжааг зогсоох болсон нөхцөл, шалтгаан арилсан тохиолдолд үнэт цаас гаргагч нь арилжааг сэргээх тухай хүсэлтээ сэргээх үндэслэлийн талаар нотлох баримтын хамт ирүүлнэ.
- 23.8 МХБ ТӨХК нь энэ журмын 23.5-р заалтын дагуу арилжаа нь зогссон компанийн үнэт цаасны арилжааг зогсоох нөхцөл, шалтгаан арилсан гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчаас хүсэлт ирүүлсэн эсэхээс үл хамааран арилжааг сэргээж болно.
- 23.9 МХБ ТӨХК нь дараах тохиолдолд үнэт цаасыг бүртгэлээс хасна:
- 23.9.1 СЗХ-ны тогтоол болон шүүхийн шийдвэрийн дагуу,
 - 23.9.2 Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар нь алдагдсан эсхүл үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон, түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн, дампуурлын хэрэг гүйцэтгэгч буюу эрх хүлээн авагч томилогдсон зэрэг тохиолдолд СЗХ, шүүх, хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу,
 - 23.9.3 Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, МХБ ТӨХК-иас тогтоосон шалгуур, шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон,
 - 23.9.4 Үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш дараалсан 6 сараас дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл, шалтгаан нь арилагүй,
 - 23.9.5 Хууль, журамд заасан бусад үндэслэлээр,

- 23.10 Үнэт цаасыг бүртгэлээс хасахад тодорхой нөхцөл, шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч болно.
- 23.11 МХБ ТӨХК нь үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн аюулгүй байдал, нэр хүндийг хамгаалах зорилгоор үнэт цаасыг бүртгэлээс хасах шалгалтыг хийж болно.
- 23.12 Үнэт цаас гаргагч нь өөрийн хүсэлтээр үнэт цаасны арилжааг зогсоох буюу хасуулах тухай хүсэлтээ МХБ ТӨХК-д гаргахаас ажлын 20-оос доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд энэ тухай мэдэгдсэн байна.
- 23.13 Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах тухай шийдвэрийг зохих журмын дагуу нийтэд мэдээлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

24 дүгээр зүйл. Бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс

- 24.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3-т заасны дагуу МХБ ТӨХК нь өргөдөл гаргагчийн хүсэлтийг хянан шийдвэрлэж, үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэх, үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, үнэт цаасны арилжааг зохион байгуулах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд бүртгэлтэй компанид үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлсийг тогтоон авах эрхтэй.
- 24.2. Үнэт цаас гаргагч буюу бүртгэлтэй компанид МХБ ТӨХК-иас үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна:
- 24.2.1 Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс
- 24.2.2 Үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлс
- 24.2.3 Жилийн үйлчилгээний хөлс
- 24.3 Үнэт цаас гаргагч нь өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсийг МХБ ТӨХК-д үнэт цаас бүртгүүлэх болон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл гаргахдаа буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлж, энэ тухай баримтыг өргөдөлдөө хавсаргана.
- 24.4 Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсний хэмжээ шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргахад 2 000 000 /хоёр сая/ төгрөг, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл гаргахад 1 500 000 /нэг сая таван зуун мянган/ төгрөг байна.
- 24.5 Хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлсийг үнэт цаас гаргагч компанийн зах зээлийн үнэлгээний 0.1 хувиар тооцож, хувьцааг нийтэд санал болгох үнэ тогтсон өдрөөс хойш 5 хоногийн дотор МХБ ТӨХК-ийн дансанд төлнө.
- 24.6 Энэ журмын 24.5-д /өмнөх заалт/ дурдсан зах зээлийн үнэлгээг хувьцааг олон нийтэд санал болгох үнээр тооцно.
- 24.7 Энэ журмын 24.5-д дурдсан хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээ I ангилалд бүртгэхэд 10 000 000 /арван сая/ төгрөгөөс багагүй, 100 000 000 /нэг зуун сая/ төгрөгөөс ихгүй, II ангилалд бүртгэхэд 5 000 000 /таван сая/ төгрөгөөс багагүй, 50 000 000 /тавин сая/ төгрөгөөс ихгүй, III ангилалд бүртгэхэд 1 000 000 /нэг сая/ төгрөгөөс багагүй, 10 000 000 /арван сая/ төгрөгөөс ихгүй байна.
- 24.8 Үнэт цаас гаргагч нь нэмж үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлөх ба хөлсийг зөвхөн нэмж бүртгүүлж буй үнэт цаасны зах зээлийн үнэлгээнээс тооцно.

- 24.9 Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд зөвхөн журмын 24.2-т заасан өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлнө.
- 24.10 Өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгөөс тооцох бөгөөд компанийн өрийн хэрэгслийн хувьд 0.05 хувь, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгслийн хувьд 0.025 хувь байна.
- 24.11 Компанийн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээ 2 500 000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс багагүй байна.
- 24.12 Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгслийн хувьд үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсний доод хэмжээг МХБ ТӨХК болон Засгийн газар, Засаг дарга, бусад эрх бүхий байгууллага хооронд байгуулах гэрээгээр зохицуулж болно.
- 24.13 Үнэт цаас гаргагч нь жилийн үйлчилгээний хөлсийг тухайн компанийн зах зээлийн үнэлгээний 0.005 хувиар тооцож, тухайн оны нэгдүгээр улиралд багтаан МХБ ТӨХК-ийн дансанд төлнө.
- 24.14 Энэ журмын 24.13-т /өмнөх заалт/ дурдсан зах зээлийн үнэлгээг тухайн хувьцааны өнгөрсөн оны жилийн дундаж ханшаар тооцно.
- 24.15 Жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ I болон II ангиллын үнэт цаасны хувьд 1 200 000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгөөс багагүй, 24 000 000 /хорин дөрвөн сая/ төгрөгөөс ихгүй, III ангиллын үнэт цаасны хувьд 500 000 /таван зуун мянган/ төгрөгөөс багагүй, 10 000 000 /арван сая/ төгрөгөөс ихгүй байна.
- 24.16 Үнэт цаас гаргагч нь бүртгэлээс хасагдах тохиолдолд тухайн жилийн бүртгэлтэй байх хоногт хувь тэнцүүлэн жилийн үйлчилгээний хөлсийг төлж болно.
- 24.17 Үнэт цаасны арилжааг зогсоосон нь жилийн үйлчилгээний хөлс төлөхгүй байх үндэслэл болохгүй.
- 24.18 Үнэт цаас гаргагч нь анх удаа МХБ ТӨХК-д үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд тухайн оны жилийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлөгдөнө.
- 24.19 Дараах тохиолдолд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг 20 хувиар хөнгөлж болно:
- 24.19.1 Үнэт цаас гаргагч нь I ангилалд нэмж үнэт цаас бүртгүүлэх,
- 24.19.2 МХБ ТӨХК-ийн хувьцааны бүртгэлийн ангилал өгсөж бүртгүүлэх,
- 24.19.3 Ногдол ашгаа үнэт цаасаар олгох, ажиллагсад үнэт цаас эзэмшүүлэх, нэгдэж нийлэх гэх мэт бодитойгоор нэмэлт хөрөнгө санхүүжилт татахгүйгээр үнэт цаасаа бүртгүүлэх,
- 24.19.4 Монгол улсын эдийн засагт их хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчит компанийн үнэт цаасыг бүртгүүлэх.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл. Хууль, журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 25.1. Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн эсвэл

хэрэгжүүлээгүй /мэдээлэл гаргаж өгөх, олон нийтэд мэдээлэх г.м/ тохиолдолд энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

- 25.2. Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-иас үзүүлэх үйлчилгээний хөлсийг журамд заасан хугацаанд тогтоосон хэмжээгээр төлөөгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-иар тооцож алданги нэмж төлнө.
- 25.3. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад МХБ ТӨХК-иас хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагч, холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 25.4. Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагад дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь эсвэл тус тусад нь тооцно.
 - 25.4.1. Албан шаардлага тавих,
 - 25.4.2. Олон нийтэд зөрчил дутагдлын талаар мэдээлэх,
 - 25.4.3. МХБ ТӨХК-ийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй мөн буруутай үйл ажиллагаа явуулсан тохиолдолд МХБ ТӨХК болон үнэт цаас гаргагчийн хооронд байгуулсан гэрээний дагуу торгууль ногдуулах,
 - 25.4.4. Үнэт цаасны арилжааг зогсоох,
 - 25.4.5. Үнэт цаасыг бүртгэлээс хасах,
 - 25.4.6. Цаашид МХБ ТӨХК-д үнэт цаас бүртгүүлэх эрхийг хязгаарлах.
- 25.5. Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо, МХБ ТӨХК нь үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагын гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруутай байдлыг харгалзаж үзнэ. Торгуулийн хэмжээг тогтоохдоо, торгууль нь буруутай талын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг мөн харгалзаж үзнэ.
- 25.6. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг тус бүртгээ хариуцна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

БУСАД

26. дугаар зүйл. Маргаан шийдвэрлүүлэх

- 26.1. МХБ ТӨХК-иас үнэт цаас гаргагчтай холбоотой гаргасан аливаа шийдвэр, урьдчилсан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээд нь МХБ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд гомдол гаргаж болно.
- 26.2. МХБ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрөх тохиолдолд, уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор СЗХ-нд гомдол гаргаж болно.

27. дугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

- 27.1. Энэхүү журам нь ТУЗ баталж, зохих журмын дагуу СЗХ-гоор батламжлуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Шинээр хувьцаа бүртгүүлэх

- 1.1 Бүртгүүлэх өргөдөл, Маягт 1
- 1.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр,
Үүнд:
- Хуулийн этгээдийн үнэт цаасыг бүртгүүлэх тохиолдолд ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/, үүсгэн байгуулагч эсхүл хуулиар зөвшөөрсөн эрх бүхий албан тушаалтны шийдвэр,
 - Засгийн газрын үнэт цаасыг бүртгүүлэх тохиолдолд Улсын их хурал /засгийн газрын харьяа агентлаг/-ын шийдвэр,
 - Аймаг, нийслэлийн үнэт цаасыг бүртгүүлэх тохиолдолд Иргэдийн төлөөлөгчдийн хурал /хуулиар зөвшөөрсөн холбогдох этгээд/-ын шийдвэр,
- 1.3 Үнэт цаас бүртгэхийг зөвшөөрсөн тухай СЗХ-ны шийдвэр,
МХБ ТӨХК болон СЗХ-нд үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг нэгэн зэрэг гаргасан компани нь шийдвэр гарсны дараа уг баримт бичгийг ирүүлж болно.
- 1.4 Хууль, журмын дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга. Танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10-р зүйл болон Хорооны бүртгэлийн журамд заасан мэдээллийг агуулах ба дараах материалыг мөн ирүүлнэ:
- 1.4.1 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар /нотриатаар гэрчлүүлсэн/,
- 1.4.2 Санхүүгийн тайлан,
- Аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлийг тодруулгын хамт аудитын тайлан, дүгнэлт, аудитын танилцуулгын хамт / Охин болон салбар, төлөөлөгчийн газартай компанийн хувьд нэгдсэн тайлан, хараат компанийн хувьд толгой компанийн тайланг тус тус ирүүлнэ /
- 1.4.3 Эд хөрөнгийн гэрчилгээний хуулбар /нотриатаар гэрчлүүлсэн/,
- 1.4.4 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан,
- 1.4.5 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл / анкет/,
- 1.4.6 Андеррайтерийн байгууллагын үнэлэлт, дүгнэлт,
- Андеррайтерийн хараат бус байдлын талаар,
- Хэрэв хувьцааг анхдагч зах зээлд андеррайтераар дамжуулахгүй өөрөө худалдах бол мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах маркетингийн төлөвлөгөө, зарласан хувьцаанаас анхдагч зах зээлд гаргах хувьцааны захиалга буюу албан бичиг /нийлүүлэх хувьцааны тоо ширхэг, үнэ, нийлүүлэлт хийх хугацаа/,
- 1.4.7 Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд оролцсон хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн зөвлөгөө үзүүлэх этгээдийн дүгнэлт,
- 1.4.8 Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд оролцсон бусад зохицуулалттай этгээдийн дүгнэлт,
- 1.4.9 Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт,
- 1.4.10 Үнэт цаасыг санал болгох хэлбэр, арга зам,

- Тогтоосон үнээр, захиалгын бүртгэлээр, дуудлага худалдаагаар зэрэг нийтэд санал болгон арилжих арга хэлбэр,
- 1.4.11 Үнэт цаасны нэрлэсэн үнэ, худалдахаар санал болгосон үнийг тогтоосон үндэслэл, тооцоо, үнийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр,
- 1.5 Зохих ангиллын шалгуурыг хангах талаар нотлох баримт, Тухайлбал:
 - 1.5.1 Өөрийн бүртгэлтэй улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан байх ба компанийн дүрэм, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн талаар зохих этгээдийн тодорхойлолт, дүгнэлт,
 - 1.5.2 Өргөдөл гаргахаас өмнөх зохих хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шалгуурыг хангаж байгааг батлах баримт,
 - 1.5.3 Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй талаарх зохих этгээдийн тодорхойлолт, Хэрэв өртэй тохиолдолд өр зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны танилцуулгад тусгасанг нотлох баримт,
 - 1.5.4 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын дэлгэрэнгүй анкет, үйл ажиллагаа явуулахад шаардагдах хангалттай туршлагатайг батлах баримт,
 - 1.5.5 Үнэт цаас хариуцсан ажилтны мэдээлэл /анкет/,
 - 1.5.6 Сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагад болон гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд, сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй болохыг тодорхойлсон албан бичиг, нотлох баримт,
 - 1.5.7 Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчим / кодекс/ -ыг дагаж мөрддөг болохыг нотлох баримт, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах.
 - 1.5.8 Андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хуулбар, андеррайтерийн танилцуулга,
 - 1.5.9 Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр тус компанийн зах зээлийн үнэлгээ нь журамд заасан болон МХБ ТӨХК-иас тухай бүр тогтоосон шаардлагыг хангах боломжтой болохыг тодорхойлох баримт,
 - 1.5.10 Хувьцааг олон нийтэд санал болгон гаргах доод хэмжээг хангах боломжтой талаар нотлох баримт,
 - 1.5.11 Хөрөнгийн биржид 2-оос доошгүй жил арилжигдсан болохыг нотлох баримт,
 - 1.5.12 Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой болохыг нотлох баримт,
 - 1.5.13 II ангилалд хувьцаа бүртгүүлэх тохиолдолд компани нь бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй болохыг нотлох баримт,
- 1.6 Үнэт цаас гаргагчийн болон андеррайтерийн мэдэгдэл, Маягт 3 - Маягт 4
- 1.7 Компанийн засаглалын талаарх эрх бүхий этгээдийн дүгнэлт, хавсаргах баримт бичиг,
- 1.8 Үнэт цаасыг хаалттай хүрээнд буюу нэр зааж эзэмшүүлэх бол үндэслэл, үнэлгээний байгууллагын болон төлбөр төлснийг батлах баримт,
- 1.9 Үнэт цаас гаргагчаас бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл, өр, зээл, барьцаа, баталгаа гаргасан бол түүний талаар баримт,
- 1.10 Журмын 24.2-т заасан өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлсөн баримт,
- 1.11 МХБ ТӨХК-ээс шаардлагатай гэж үзсэн бусад материал,

2. Нэмж хувьцаа бүртгүүлэх

- 2.1 Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, Маягт 1
- 2.2 Шинээр хувьцаа бүртгүүлэхэд бүрдүүлдэг баримт бичгүүдээс шаардлагатай хэсгийг /Үнэт цаасны танилцуулга, Андеррайтерийн дүгнэлт, мэдэгдлүүд, үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн болон СЗХ-ны шийдвэр гэх мэт/
- 2.3 Хувьцаа эзэмшигчид хүлээн зөвшөөрч байгаа талаар нотлох баримт,
- Хуулийн дагуу хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар баримт материал,
 - Тэргүүн ээлжид эзэмшүүлэх эсэх талаар гаргасан шийдвэр, үндэслэл ба тайлбар, авч хэрэгжүүлсэн ажиллагааны хэрэгжилт,
 - Өрийг хувьцаанд хөрвүүлэх замаар нэмэлт хувьцаа бүртгүүлэх тохиолдолд “өрийг хувьцаагаар солих төсөл”-ыг хүлээн зөвшөөрсөн талаар баримт,
- 2.4 Бүртгэлийн журмын Зургадугаар бүлэгт заасан тогтмол биелүүлэх үүргийн хэрэгжилт сайн биелэлттэй байгааг тодорхойлсон албан бичиг,
- 2.5 Өрийг хувьцаагаар солих тохиолдолд өр үүссэнийг батлах баримт, зээлдэгч, харилцагч нар нь өрийг хувьцаагаар солих ажиллагааг хүлээн зөвшөөрсөн талаар баримт,
- 2.6 Журмын 24.2-т заасан өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлсөн баримт,
- 2.7 МХБ ТӨХК-иас шаардлагатай гэж үзсэн бусад материал,

3 Өрийн хэрэгсэл бүртгүүлэх

- 3.1 Өрийн хэрэгсэл бүртгүүлэх өргөдөл, Маягт 2
- 3.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр,
- 3.3 Үнэт цаас бүртгэхийг зөвшөөрсөн тухай СЗХ-ны шийдвэр,
- 3.4 Хууль, журмын дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга, Танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10-р зүйл болон Хорооны бүртгэлийн журамд заасан мэдээллийг агуулна.
- 3.5 Өрийн хэрэгслээр татах хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн мэдээлэл,
- 3.6 Өрийн хэрэгслийг зах зээлд нийлүүлэх арга хэлбэр, захиалга / Тоо ширхэг, үнийн дүн, нэгжийн үнэ, хүүгийн хэмжээ, хүү болон үндсэн төлбөр хийх хугацаа /-ын талаар мэдээлэл,
- 3.7 Өрийн хэрэгслийн төлбөрийн найдвартай байдлыг хангахтай холбоотой барьцаа баталгааны баримт,
- /Засгийн газраас гаргасан болон Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан өрийн хэрэгслийн хувьд барьцаа, баталгааны баримт бүрдүүлэхгүй байж болно/
- 3.8 Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийг нотлох баримтууд,
Тухайлбал:
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар /нотриатаар гэрчлүүлсэн/,
 - Аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлийг тодруулгын хамт аудитын тайлан, дүгнэлт, аудитын танилцуулгын хамт / Охин болон салбар, төлөөлөгчийн газартай компанийн хувьд нэгдсэн тайлан, хараат компанийн хувьд толгой компанийн тайланг тус тус ирүүлнэ /,
 - Эд хөрөнгийн гэрчилгээний хуулбар /нотриатаар гэрчлүүлсэн/,

- Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан,
 - Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл /анкет/,
 - Андеррайтерийн байгууллагын үнэлэлт, дүгнэлт,
 - Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд оролцсон хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн зөвлөгөө үзүүлэх этгээдийн дүгнэлт,
 - Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд оролцсон бусад зохицуулалттай этгээдийн дүгнэлт,
 - Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт,
- 3.9 МХБ ТӨХК-д өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд тавигдах шалгуурыг хангах талаар нотлох баримт,
- 3.10 Үнэт цаас гаргагчийн болон андеррайтерийн мэдэгдэл, Маягт3 - Маягт 4
- 3.11 Журмын 24.2-т заасан өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлсөн баримт,
- 3.12 МХБ ТӨХК-иас шаардлагатай гэж үзсэн бусад материал,

4 Бүртгэлд өөрчлөлт оруулах, Бүртгэлийн ангилал өгсүүлж /бууруулж бүртгэх

- 4.1 Бүртгэлд өөрчлөлт оруулахыг хүссэн хүсэлт,
- 4.2 Өөрчлөлт оруулах болсон шалтгаан, үндэслэл тайлбар /нотлох баримт/,
- 4.3 Үнэт цаасны талаарх мэдээлэл /Бүртгэлд өөрчлөлт орохоос өмнөх болон орсны дараах байдлаар/,
- 4.4 Хууль тогтоомж болон холбогдох журам зааврын хүрээнд бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн хурлаар эсвэл ТУЗ хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болохыг нотлох баримт,
- 4.5 Компанийг өөрчлөн байгуулах талаар шүүхийн шийдвэр,
- 4.6 Хорооны бүртгэлийн журмын хорьд заасны дагуу СЗХ-нд бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийн хамт хүргүүлэх зохих шийдвэр, баримт бичгүүдийн хувийг ирүүлэх,
- 4.7 Бүртгэлд өөрчлөлт оруулах огноо /урьдчилсан байдлаар/,
- 4.8 Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдээллийг үнэт цаас эзэмшигчдэд, шаардлагатай тохиолдолд зээлдэгчид болон бусад харилцагчид мэдэгдсэн талаар нотлох баримт,
- 4.9 Өөрчлөн байгуулалтын үр дүнд шинээр бий болсон компанийн дүрэм, гэрчилгээ, хаяг, байршил, оноосон нэр, өөрчлөн байгуулагдах үеийн дуусгалтын болон эхлэлтийн санхүүгийн тайлан тэнцэл,
- 4.10 Шинээр бий болж байгаа компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл /анкет/,
- 4.11 Бүртгэлийн ангилал өгсүүлж /бууруулж бүртгүүлэхдээ нэмэлт үнэт цаас гаргах тохиолдолд шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэхэд бүртгүүлэх материалаас шаардлагатай хэсгийг ирүүлэх,
- 4.12 Бүртгэлийн ангилал өгсүүлж /бууруулж бүртгэхэд, шилжин орж буй ангиллын шалгуурыг хангаж байгааг нотлох баримт,
- 4.13 Ангилал өгсүүлж бүртгэх тохиолдолд хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын хугацаанд үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан нь хууль, журам зөрчиж, хариуцлага хүлээж байгаагүй болохыг батлах баримт,
- 4.14 Журмын 24.2-т заасан өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлсөн баримт,
- 4.15 МХБ ТӨХК-иас шаардлагатай гэж үзсэн бусад материал,

5 Үнэт цаасны арилжаа зогсоолгох, бүртгэлээс хасуулах

- 5.1 Үнэт цаас гаргагч нь өөрийн хүсэлтээр үнэт цаасны арилжааг зогсоолгох ба бүртгэлээс хасуулах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ:
- 5.2 Журмын 23.2-р зүйлд тусгасан мэдээллийг агуулсан үнэт цаас бүртгэлээс хасуулах тухай хүсэлт,
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн холбогдох шийдвэр,
- 5.4 Компанийг өөрчлөн зохион байгуулах бол өөрчлөн зохион байгуулах төсөл/ төсөлд компанийг өөрчлөн зохион байгуулах шалтгаан, зорилго, хувьцааг хөрвүүлэх арга, тооцоог тусгасан байна/,
- 5.5 Компанийг өөрчлөн зохион байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан буюу хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, түүнийг баталж, мөрдөх тухай шийдвэр,
- 5.6 Хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоосон үндэслэл, шийдвэр /үнэ тогтоосон үнэлгээний байгууллагын дүгнэлт /,
- 5.7 Компанийг татан буулгаж байгаа бол татан буулгах комисс байгуулсан тухай эрх бүхий этгээдийн шийдвэр,
- 5.8 Компанийг татан буулгасны дараа нэхэмжлэл гаргах журам, үлдэгдэл эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам,
- 5.9 Өөрчлөн зохион байгуулагдах болон татан буугдах үеийн дуусгалтын тайлан баланс,
- 5.10 МХБ ТӨХК-д үйлчилгээний хөлсийн болон бусад өр төлбөртэй тохиолдолд өр төлбөрийг төлж барагдуулсан болохыг нотлох баримт,
- 5.11 Хууль, тогтоомж болон Хорооны бүртгэлийн журамд заасан шаардлагатай бусад мэдээлэл,

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Шинээр болон нэмж хувьцаа бүртгүүлэхэд/

Хэнд: Монголын хөрөнгийн бирж,
Бүртгэлийн алба

Огноо:

Эрхэм танаа,

Бид [Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] энэхүү маягтын 2-т тусгасан үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах хорооны “Үнэт цасны бүртгэлийн журам” болон Монголын хөрөнгийн бирж /цаашид МХБ ТӨХК гэх/-ийн “Бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

I. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр:

1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

1.3 Регистерийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Үүсгэн байгуулагдсан огноо:
/тасралтгүй үйл ажиллагаа явуулсан жил/*

1.6 Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

1.7 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

1.8 Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:*

1.9 Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:
/5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ/

--

1.10 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг, ТУЗ /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүд, үнэт цаас хариуцсан ажилтаны талаарх мэдээлэл: *
/Гүйцэтгэх удирдлага буюу удирдлагын багийн хувьд тэдний боловсрол мэдлэг, туршлага зэргийг тодорхой бичнэ/

--

1.11 Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл: *

--

1.12 Одоогоор МХБ ТӨХК-д үнэт цаас гаргагчийн үнэт цаас бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл: *
/Хэрэв тийм бол бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх бүртгэлтэй үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх талаар бичнэ/

--

1.13 Өмнө нь аль нэгэн хөрөнгийн биржид бүртгэлтэй байсан эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй бирж:

--

1.14 Өмнө нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн хөрөнгийн биржийн шийдвэрийн дугаар, огноо:

--

1.15 Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

--

1.16 Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эсэх: *

--

II. Үнэт цаасны мэдээлэл:

2.1 Үнэт цаасны нэр:

2.2 Үнэт цаасны код /үсгэн ба тоон/
/Шинээр үнэт цаас бүртгүүлэх компани нь
үнэт цаасанд олгох үсгэн кодны саналаа
бичнэ/

2.3 Үнэт цаасны төрөл:

2.4 Үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн
арга:*

2.5 Хадгаламжийн бичиг хэлбэрээр
бүртгүүлэх бол суурь үнэт цаасны
талаарх мэдээлэл: *
/Бүртгэлтэй бирж, бүртгэгдсэн
хэмжээ, үнэ, төрөл гэх мэт мэдээллийг
бичнэ/

2.6 Бүртгүүлэх үнэт цаасны тоо
ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн:
/Хувьцааны төрөл тус бүрээр нийтэд санал
болгохоос өмнөх болон нийтэд санал
болгосны дараах байдлаар бичнэ/

2.7 Үнэт цаасны нийтэд санал болгох
хувь хэмжээ, үнэ, арга хэлбэр:
/Хувьцааны төрөл (энгийн ба давуу
эрхийн) тус бүрээр бичнэ/

2.8 Үнэт цаас гаргах замаар нийтээс
таган төвлөрүүлэхээр тооцсон
хөрөнгийн хэмжээ:
/Хувьцааны төрөл (энгийн ба давуу
эрхийн) тус бүрээр бичнэ/

2.9 Үнэт цаас гаргах замаар нийтээс
таган төвлөрүүлэх хөрөнгийн
зарцуулалтын талаарх товч
мэдээлэл:

2.10 Үнэт цаасыг нийтэд санал болгон
арилжихаар төлөвлөсөн хугацаа:

3 Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл:

3.1.1 *Андеррайтерийн оноосон нэр:*
/Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол
энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/

3.1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн
дугаар:

- 3.1.3 Регистрийн дугаар:
- 3.1.4 Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/
- 3.1.5 Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/
- 3.1.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 3.2.1 **Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:**
- 3.2.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:
- 3.2.3 Регистрийн дугаар:
- 3.2.4 Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/
- 3.2.5 Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/
- 3.2.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 3.2.7 **Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан бол энэ тухай мэдээлэл:**
/ Нэр, эрхэлдэг ажил, алба /хуулийн этгээд бол хаяг байршил/, боловсрол, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал зэргийг бичнэ/

* - СЗХ-ны 2014 оны 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хавсралт 1-д зааснаас гадна МХБ-ийн зүгээс өргөдөлд тусгах шаардлагатай гэж үзсэн мэдээлэл.

3.3 Энэхүү маягтын 3-р хэсэгт багтах зөвлөгөө өгсөн этгээдүүд нь уг журамд хавсаргасан маягт 3-ын дагуу мэдэгдэл гаргана.

3.4 Зохицуулалттай хуулийн этгээд үнэт цаас гаргах ажиллагаанд оролцоогүй тохиолдолд тус этгээд оролцоогүй шалтгааны талаар тайлбар гаргана.

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны таницуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:

2. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

(Тамга/ тэмдэг)

3. Овог, нэр:

4. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

(Тамга/ тэмдэг)

5. Овог, нэр:

6. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
Ерөнхий нягтлан бодогч
.....

Албан тушаал: Хуулийн зөвлөгөө үзүүлэх
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

(Тамга/ тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн МХБ ТӨХК-ийн ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд/

Хэнд: Монголын хөрөнгийн бирж,
Бүртгэлийн алба

Огноо:

Эрхэм танаа,

Бид [Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] энэхүү маягтын 2-т тусгасан үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон Монголын хөрөнгийн бирж /цаашид МХБ ТӨХК гэх/-ийн “Бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр:

1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

1.3 Регистерийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Үүсгэн байгуулагдсан огноо: *
/тасралтгүй үйл ажиллагаа явуулсан жил/

1.6 Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

1.7 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

1.8 Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас: *

1.9 Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:
/5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенифициар өмчлөгчийг мөн бичнэ/

--

1.10 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг, ТУЗ /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүд, үнэт цаас хариуцсан ажилтаны талаарх мэдээлэл:*

/Гүйцэтгэх удирдлага буюу удирдлагын багийн хувьд тэдний боловсрол мэдлэг, туршлага зэргийг тодорхой бичнэ/

--

1.11 Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл:*

--

1.12 Одоогоор МХБ ТӨХК-д үнэт цаас гаргагчийн үнэт цаас бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл:*

/Хэрэв тийм бол бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх бүртгэлтэй үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх талаар бичнэ/

--

1.13 Өмнө нь аль нэгэн хөрөнгийн биржид бүртгэлтэй байсан эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй бирж:

--

1.14 Өмнө нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн хөрөнгийн биржийн шийдвэрийн дугаар, огноо:

--

1.15 Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

--

1.16 Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эсэх:*

--

2. Үнэт цаасны мэдээлэл:

2.1 Үнэт цаасны нэр:

2.2 Үнэт цаасны төрөл:

2.3 Үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн арга:*

2.4 Үнэт цаасны тоо ширхэг, үнэ, үнийн дүн:

2.5 Үнэт цаасны хугацаа, хүү:
/Хүүгийн хувь хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн хэрэгслийн хугацаа зэргийг бичнэ/

2.6 Үнэт цаасны нөхцөл:
/хямдруулсан, хөрвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас өмнө эргүүлэн татах гэх мэт/

2.7 Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, хэлбэр, үнэ:

2.8 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:

2.9 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаарх товч мэдээлэл:

2.10 Үнэт цаасны барьцаа, баталгааны талаарх мэдээлэл:*

2.11 Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ, санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон бол тэр талаарх мэдээлэл:*

2.12 Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл:

3.1.1 *Андеррайтерийн оноосон нэр:*
/Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/

- 3.1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:
- 3.1.3 Регистрийн дугаар:
- 3.1.4 Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/
- 3.1.5 Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/
- 3.1.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 3.2.1 **Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:**
- 3.2.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:
- 3.2.3 Регистрийн дугаар:
- 3.2.4 Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/
- 3.2.5 Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/
- 3.2.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 3.2.7 **Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан бол энэ тухай мэдээлэл:**
/ Нэр, эрхэлдэг ажил, алба /хуулийн этгээд бол хаяг байршил/, боловсрол, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал зэргийг бичнэ/

* - СЗХ-ны 2014 оны 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хавсралт 1-д зааснаас гадна МХБ-ийн зүгээс өргөдөлд тусгах шаардлагатай гэж үзсэн мэдээлэл.

3.3 Энэхүү маягтын 3-р хэсэгт багтах зөвлөгөө өгсөн этгээдүүд нь уг журамд хавсаргасан маягт 3-ын дагуу мэдэгдэл гаргана.

3.4 Зохицуулалттай хуулийн этгээд үнэт цаас гаргах ажиллагаанд оролцоогүй тохиолдолд тус этгээд оролцоогүй шалтгааны талаар тайлбар гаргана.

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны таницуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

4 Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

5 Овог, нэр:

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

6 Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

7 Овог, нэр:

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

8 Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
Ерөнхий нягтлан бодогч
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

9 Овог, нэр:

Албан тушаал: Хуулийн зөвлөгөө үзүүлэх
“.....”К-ийн
Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн МХБ ТӨХК-ийн ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Огноо

I. Үнэт цаас гаргагч компанийн мэдэгдэл:

1. Үнэт цаас гаргагч[Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна:
 - 1.1. МХБ ТӨХК-ийн Бүртгэлийн журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
 - 1.2. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой МХБ ТӨХК-ийн “Бүртгэлийн журам”-д тусгагдсан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
 - 1.3. “Бүртгэлийн журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
 - 1.4. Үнэт цаас бүртгүүлэх зөвшөөрөл авахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн өргөдөлд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд МХБ ТӨХК-д нэн даруй мэдээлнэ.
 - 1.5. Худал, ташаа мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Түүнчлэн үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-д бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
 - 2.1. Манай үнэт цаас МХБ ТӨХК-д бүртгэгдсэн нөхцөлд МХБ ТӨХК-ийн “Бүртгэлийн журам” болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
 - 2.2. Өргөдлийг хүлээн авч, үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ СЗХ болон МХБ ТӨХК-д хүргүүлнэ.
 - 2.3. Үнэт цаас гаргагч нь “Бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

II. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл:

1. Би[үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага] өөрийн эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж болон СЗХ, МХБ ТӨХК-ийн холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.
2. Дараах зүйлсийг МХБ ТӨХК-ийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ:

- 2.1. МХБ ТӨХК-ийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг хүргүүлэх,
 - 2.2. МХБ ТӨХК-ийн зүгээс “Бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах,
 - 2.3. Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,
3. Энэ журмын 12.1.4, 12.1.5 /13.1.6/-р заалтанд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтны шалгуур, нөхцөлийг хангаж байгааг мэдэгдэж байна.
 4. Би жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бөгөөд миний албан тушаал, холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд МХБ ТӨХК-д нэн даруй мэдэгдэнэ.
 5. Үнэт цаас бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материалд /үнэт цаасны танилцуулга хамаарна/орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
 6. Энэхүү мэдэгдлийн 3, 4-т /дээрх заалтууд/ тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

III. МХБ ТӨХК-иас үзүүлэх үйлчилгээний хөлстэй холбоотой мэдэгдэл:

1. Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс төгрөгийг –ны өдөр дугаартай чекээр банкны дансанд төлсөн. /Баримтын хуулбарыг хавсаргах/
2. Олон нийтэд санал болгон худалдах нэгж хувьцааны үнэ тодорхой болсон тохиолдолд журмын 24.5-д заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг МХБ ТӨХК-д төлөхөө мэдэгдэж байна.
3. Хэрэв МХБ ТӨХК нь өргөдөлд тусгасан үнэт цаасыг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан тохиолдолд үнэт цаас гаргагчийн төлсөн өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
4. Хувьцаа нь бүртгэлтэй байх хугацаанд журмаар тогтоосон хувь хэмжээгээр, заасан хугацаанд нь жилийн үйлчилгээний хөлсийг төлөхөө мэдэгдэж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

Огноо:

Бид [Андеррайтерийн байгууллага, түүнийг төлөөлж] байршилтай, МХБ ТӨХК-ийн “Бүртгэлийн журам”-ын 12.1.7-д заасны дагуу компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгоход андеррайтерийн үүрэг гүйцэтгэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

1. Компанийн үнэт цаас бүртгүүлэх өргөдлийн маягт болон “Бүртгэлийн журам”-ын дагуу шаардлагатай бүхий л материалыг МХБ ТӨХК-д хүргүүлсэн.
2. Бид хуульд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсаны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулсанаа мэдэгдэж байна:
 - 2.1.1. Андеррайтер нь Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцөлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материалд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, материал орхигдуулаагүй болно.
 - 2.1.2. Үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас бүртгүүлэх өргөдөлтэй хамт хүргүүлж буй андеррайтерийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
 - 2.1.3. Андеррайтер нь үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.
 - 2.1.4. Бид андеррайтерийн дүгнэлт гаргах, үнэт цаасны танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
 - 2.1.5. Үнэт цаас гаргагч компанийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг дангаар болон биеэ даан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд бүртгэлтэй компани болсноор хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
 - 2.1.6. Үнэт цаас гаргагч компани нь бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсэний дараах үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

Баталгаажуулсан:

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Овог, нэр:

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
.....

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/ тэмдэг)

(Тамга/ тэмдэг)

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд:

№

Огноо:

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга: тухай		
Үндэслэл:			
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/			
Үнэт цаасны нэр:			
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/			
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/			
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/			
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/			
Энгийн	тоо /ширхэг/		
	хувь /%/		
Давуу эрхийн	тоо /ширхэг/		
	хувь /%/		
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/		
	хувь /%/		
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/		
	хувь /%/		
Хаалттай хүрээнд	тоо /ширхэг/		
	хувь /%/		
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/			
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/			
Үнэт цаасны нөхцөл: /хямдруулсан, хөрвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас өмнө эргүүлэн татах гэх мэт/			
Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь хэмжээ:			
Үнэт цаасны хугацаа:			
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа /давтамж/:			
Бусад:			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../